

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР БОЛОН ХОРООДЫН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ ХӨГЖИЛ,
ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

2024 оны 12 дугаар сарын 25

Улаанбаатар хот

№	Үйл ажиллагааны чиглэл	Үйл ажиллагааны нэр	Хэрэгжилт, /гүйцэтгэлийн хувь/	Хүрсэн үр дүн
1.СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГАА ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД				
1.1. Албан хаагчдыг сургаж мэргэшүүлэх чиглэлээр				
1.	2024 онд шинээр дагаж мөрдөж эхлэх болон шинэчлэн найруулсан хууль, журмын талаарх мэдлэг олгох	Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн мэдлэг олгох сургалтад албан хаагчдыг хамруулах.	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн хэлтсээс 1, 3, 9, 11 дүгээр саруудад зохион байгуулсан Төрийн албан хаагчийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн богино хугацаат хуваарьт сургалтад ЗДТГ, хороодод шинээр томилогдсон 8 албан хаагчийг хамруулсан. Хэрэгжилт 100%	Албан хаагчид Төрийн албан хаагчийн дагаж мөрдөх хууль, хөдөлмөрийн харилцааны мэдлэгтэй болсон.
2.		ЗГХЭГ-ын даргын 2023 оны 98 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ыг эзэмших сургалтад албан хаагчдыг хамруулах.	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн хэлтсээс 1, 3, 9, 11 дүгээр саруудад зохион байгуулсан Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, бодлогын баримт бичиг боловсруулах арга зүй олгох 2 өдрийн гэрчилгээт сургалтад ЗДТГ-ын 2, хорооны 1, богино хугацаат сургалтад ЗДТГ-ын 5, хороодын 16, нийт 24 албан хаагчдыг хамруулсан. Хэрэгжилт 100%	Албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан, бодлогын баримт бичиг боловсруулах арга, аргачлалыг эзэмшсэн.
3.	Мэргэшүүлэх сургалт	Удирдлагын академиас зохион байгуулдаг төрийн албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалтад хамруулах.	Удирдлагын академийн сургалт судалгааны 2024 оны төлөвлөгөөний дагуу төрийн албан хаагчдад олгодог эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1 албан тушаалтан, дунд хугацааны мэргэшүүлэх давтан сургалтад 3 албан хаагч, дунд хугацааны мэргэшүүлэх багц сургалтад 4 албан хаагч, нийт 8 албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалтад хамруулсан. Хэрэгжилт 100%	Албан тушаалын чиг үүргээ амжилттай хэрэгжүүлэх, эрхэлж буй албан тушаалын онцлог, ажлын шаардлагад нийцсэн мэдлэг чадварыг эзэмшсэн.

4.		Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх сургалтад хамруулах.	Төрийн албанд шинэ томилогдсон албан хаагчийг чиглүүлэх 40 цагийн сургалтад 3 албан хаагчийг 2024 оны 11 дүгээр сарын 18-22-ны өдрүүдэд хамруулсан. Хэрэгжилт 100%	Төрийн албаны онцлог, ёс зүй, хариуцлага, төрийн байгууллагын бүтэц, чиг үүрэг, ажлын зохион байгуулалт, технологи ашиглах арга зүй эзэмшсэн.
5.	А3 гэрчилгээ олгох сургалт	Худалдан авах ажиллагааны А3 гэрчилгээ олгох сургалтад албан хаагчдыг хамруулах.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд А3 гэрчилгээ олгох сургалтад Засаг даргын Тамгын газрын удирдах, гүйцэтгэх албан тушаалын 24 албан хаагчийг хамруулж, 14 албан хаагч сертификат авсан. Хэрэгжилт 100%	"А3" гэрчилгээ шинээр авсан албан хаагчид ЗДТГ-аас зарласан худалдан авах ажиллагааны нээлттэй сонгон шалгаруулалтын үнэлгээний хороонд ажиллах боломж бүрдсэн.
6.	Туршлага солилцох арга хэмжээ	Засаг даргын Тамгын газар болон хорооны албан хаагчид ажлын байран дээр туршлага судлах, харилцан суралцах болон зөвлөн туслах арга хэмжээг зохион байгуулах.	Засаг даргын Тамгын газар хорооны албан хаагчдыг дараах чиглэлээр зөвлөгөө, мэдээллээр хангаж, хариуцсан чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. Үүнд; • Батлагдсан албан тушаалын тодорхойлолтын дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг боловсруулах • Албан хаагчдын цалингийн шатлал, нэмэгдлийг танилцуулах, • Засаг даргын Тамгын газарт мөрдөгдөж буй дүрэм, журамтай танилцах, хэрэгжүүлэх байдалд хяналт тавих. Хэрэгжилт 100%	Зөвлөн туслах үйл ажиллагааны хүрээнд Засаг даргын Тамгын газар болон хорооны нийт 45 албан хаагчдыг ажлын байран дээр зөвлөгөө, мэдээллээр хангасан. Албан хаагчид ажил үүрэгтэй холботой сургалтад тухай бүр хамрагдаж, ур чадвараа дээшлүүлэх боломж бүрдсэн.
7.	Албан хаагчдын хувь хүний хөгжил, олон нийтийн арга хэмжээ	Албан хаагчдын харилцаа, сэтгэл зүйн эрүүл мэндийн чиглэлээр арга хэмжээнд албан хаагчдыг хамруулах.	Сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих "Стрессийг даван туулах нь" сэдэвт сургалтыг ШУТИС-ийн сэтгэл судлалын багш Б.Баярмаагаар удирдуулан 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр танхимаар ЗДТГ-ын 60 албан хаагч, 2024 оны 5 дугаар сарын 28-ны өдөр цахимаар хорооны төрийн захиргааны 60 албан хаагч, 200 хэсгийн ахлагчийг хамруулсан. Хэрэгжилт 100%	Ажлаас үүсэх стрессийг таних, стрессийн шалтгаант бие мах бодийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг чадвар эзэмшсэн.
8.		Хамт олны уур амьсгалыг дээшлүүлэх чиглэлээр олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах.	- Байгууллагын хамтач соёл, хамт олны уур амьсгалыг дээшлүүлэх зорилго бүхий "Эртэч Хан-Уулчууд" өглөөний уулзалт арга хэмжээг 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдөр Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс зохион байгуулж ЗДТГ-ын 70 албан хаагч,	Шинэ томилогдсон албан хаагчидтай танилцах, байгууллагад эерэг уур амьсгалыг нэмэгдүүлэх нөхцөл бүрдүүлсэн.

			- Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Засаг даргын Тамгын газрын спорт хамтлаг хамтран 2024 оны 3 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулсан “Цасны баяр”-ын арга хэмжээнд 60 албан хаагч, - Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс “Эртэч монгол” хөтөлбөрийн санаачлагч, илтгэгч Н.Энхбаатарын “Эерэг харилцаа” сэдэвт илтгэлийг 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр зохион байгуулж 70 албан хаагч тус тус хамрагдсан. - Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтээс шинээр томилогдсон болон шилжин томилогдож буй албан хаагчдаа угтах, үдэх арга хэмжээний хүрээнд ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай бичгийн хэрэгсэл, хамт олны мэндчилгээгээр бэлэг барих санаачлага гарган, Засаг даргын Тамгын газрын нийт хэлтэс, албадад уриалга хүргүүлсэн. Хэрэгжилт 50%	
9.	Бусад	Засаг даргын Тамгын газар болон хорооны албан хаагчдыг эрхэлж буй ажлын чиглэлээр бусад мэргэжлийн болон дээд байгууллагаас зохион байгуулсан сургалт, уулзалт, зөвлөгөөнд тухай бүр оролцуулна.	НЗДТГ-ын Хүний нөөцийн хөгжлийн төв болон бусад байгууллагаас цаг үеийн шинжтэй 30 төрлийн сургалтад давхардсан тоогоор 930, форум, зөвлөгөөн, тэмцээн зэрэг 8 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор 496 албан хаагчийг тус тус хамруулсан. Мөн тайлант хугацаанд Төрийн албаны зөвлөлийн "7-4-10" зорилтот 11 удаагийн цахим сургалтад 150 төрийн албан хаагч, хорооны хэсгийн ахлагчдыг хамруулсан. Хэрэгжилт 100%.	Албан хаагчид хууль тогтоомж, төрөөс хэрэгжүүлж буй бодлого, мэргэжлийн болон цаг үеийн мэдээллээр хангагдсан.
НИЙТ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, 94.4%				
2. ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД				
10.	Албан хаагчдыг соён гэгээрүүлэх	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, ЗДТГ-ын даргын 2021 оны А/35 дугаар тушаалаар батлагдсан “Захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын дагаж мөрдөх харилцаа, хандлагын	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн дагаж мөрдөх ёс зүйн хэм, хэмжээ”, Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Ёс зүйн	Албан хаагчид үндэсний хөтөлбөр, ёс зүйн хэм хэмжээ болон ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны талаар ойлголт, мэдээллээр хангагдсан.

		нийтлэг журам"-ыг таниулж ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлнэ.	дэд хорооны ажиллах журам"-ыг албан хаагчдад таниулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилтын хүрээнд Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн дэд хорооноос 2024 оны I улирлын үйл ажиллагааны тайлан, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл танилцуулах 5 удаагийн арга хэмжээнд 04 дүгээр сарын 03-11-ний өдрүүдэд Засаг даргын Тамгын газрын 56, хорооны 49, нийт 105 албан хаагчдыг хамруулсан. Хэрэгжилт 100%	
11.		Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулна.	-Төрийн албан хаагчдын ёс зүйн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, оролцоо идэвхийг сайжруулах зорилтын хүрээнд Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Ёс зүйн хорооны гишүүн М.Цэрэнбаттай хамтран “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт илтгэлийг 2024 оны 11 зохион байгуулж, Засаг даргын Тамгын газрын 39, хорооны 46, нийт 85 албан хаагч хамрагдсан. -Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Ёс зүйн хорооны 7-4-10 зорилтот сургалтын хүрээнд 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр цахимаар зохион байгуулсан “Дижитал ёс зүй” сэдэвт сургалтад 25 хорооны 138 хэсгийн ахлагчдыг хамруулж цахим орчинд ёс зүйтэй харилцах мэдлэг олгосон. -Хан-Уул дүүргийн Газар зохион байгуулалтын албаны албан хаагчдад Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хууль болон холбогдох баримт бичгийг таниулах, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, ажиллах журмыг танилцуулах уулзалт арга хэмжээг 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулж, уулзалтад тус албаны 14 албан хаагч хамрагдсан. Хэрэгжилт 100%	Албан хаагчдад ёс зүйн ойлголт, эерэг хандлага төлөвшсөн.
12.	Зөрчил хянан шийдвэрлэх	Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас төрийн албан хаагчийн ёс зүйд хамаарах асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг ёс зүйн дэд хорооны хурлаар шийдвэрлэнэ.	Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар иргэдээс ирүүлсэн 11 албан хаагчид холбогдох гомдол, мэдээллийг 5 удаагийн хурлаар хэлэлцэн, ёс зүйн зөрчил тогтоогдсон 3 албан хаагчид Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.2 дахь заалтад заасан ёс зүйн хариуцлага хүлээлгэж, 5 албан хаагчид ёс	Албан хаагчдын ёс зүйн талаарх мэдлэг ойлголт нэмэгдэж, сүүлийн хагас жилд ёс зүйн асуудлаар ирүүлсэн өргөдөл гомдол 30 хувиар буурсан.

			зүйн дэд хорооны зөвлөмжийг хүргүүлсэн. Хэрэгжилт 100%	
13.		Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн зөрчлийн тухай мэдээг төрийн албаны зөвлөлийн холбогдох байгууллагад тухай бүр хүргүүлнэ.	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа болон төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчлийн тайлан мэдээллийг хагас, бүтэн жилээр нэгтгэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороонд 2 удаа хүргүүлж, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны талаарх мэдээллийг www.khanuul.mn цахим хуудасны Ил тод байдал цэсэнд улирал тутам шинэчлэн байршуулсан. Хэрэгжилт 100%	Дээд байгууллага болон иргэд, олон нийт Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны талаар нээлттэй мэдээллээр хангагдсан.
НИЙТ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, 100%				
3. БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДЫН АЖЛЫН САХИЛГА ХАРИУЦЛАГЫГ САЙЖРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД				
14.	Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх	Албан хаагчдад сахилга, дэг журмыг сахиулах чиглэлээр ЗДТГ-ын Хөдөлмөрийн дотоод журмыг таниулах, хэрэгжилтэд хяналт тавих, шинэ томилогдсон албан хаагчдыг арга зүйгээр хангах, чиглүүлэх.	- Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, төрийн албаны соёл, дэг журмыг сахиулах, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлэх зорилго бүхий дүүргийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр албан даалгаврыг Засаг даргын дэргэдэх байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, хороодын нийт төрийн 100 байгууллагад 2024 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 03/614 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. - Засаг даргын Тамгын газрын хэлтэс албанд томилогдсон 12, хороодод томилогдсон 18, нийт шинээр томилогдсон 30 албан хаагчид Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ЗДТГ-ын Хөдөлмөрийн дотоод журам болон бусад хууль, тогтоомж, дүрэм журмыг танилцуулж, өдөр тутмын ажил үүргийн хүрээнд хэрэгжүүлж, хэвшүүлэх арга зүйн зөвлөгөө өгсөн. Хэрэгжилт 100%	Дүүргийн нутаг дэвсгэр дэх төрийн байгууллагад үүрэг гүйцэтгэж буй төрийн албан хаагчдын баримталж ажиллах сахилга, ёс зүйн шаардлагыг таниулсан.
15.		Төрийн албан хаагчийн гаргасан сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж шалтгаан нөхцлийг тогтооно.	Төрийн албан хаагчийн ёс зүй зөрчил 3, сахилгын зөрчил 1 тогтоогдсоноос: - Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн	Албан хаагчдын ёс зүйн болон сахилгын шалтгаан нөхцлийг илрүүлж, холбогдох арга хэмжээ авсан.

			• 8 дугаар зүйлийн 8.1.1,-т заасан Иргэний хүсэлтэд анхааралтай хандаж, хууль заасан бүрэн эрхийнхээ хүрээнд хариу өгөх шаардлагыг зөрчсөн зөрчил 1, • 8 дугаар зүйлийн 8.1.2-т заасан Эрх бүхий байгууллагаас баталсан хувцаслалтын шаардлагыг зөрчсөн зөрчил 1, • 8 дугаар зүйлийн 8.2.1-т заасан Төрийн албан хаагчийн хувьд хуулиар тогтоосон иргэний эрх, эрх чөлөөний хязгаарлалтыг үг, үйлдлээр эсэргүүцэх, бусдыг өдөөн турхирах зөрчил 1, - Хөдөлмөрийн тухай хуулийн 123.1, Хөдөлмөрийн дотоод журмын 13.3.1-т заасан ажлын цаг ашиглалтын зөрчил 1 тус тус тогтоогдсон. Хэрэгжилт 100%	
16.		Судалгаа, дүн шинжилгээний үр дүнд үндэслэн албан хаагчдын сахилга, хариуцлагыг сайжруулах чиглэлээр нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулна.	Албан хаагчдын гаргасан ёс зүйн болон сахилгын зөрчлийн шалтгаан нөхцөлд үндэслэн Төрийн албан хаагчид ажлын цагаар, ажлын байран дээрх хувцаслалтандаа Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 8.1.2, Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын "Захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын дагаж мөрдөх харилцаа, хандлагын нийтлэг журам"-ын 3.2-т заасан шаардлагыг мөрдөх анхааруулга, зурагт хуудсыг Засаг даргын Тамгын газар, хороодын албан хаагчдын цахим бүлгэмд 2024 оны 6 дугаар сарын 17-ны өдөр байршуулж, мэдээллээр хангасан. Хэрэгжилт 100%	Төрийн албаны тухай хууль, Засаг даргын Тамгын газрын "Захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын дагаж мөрдөх харилцаа, хандлагын нийтлэг журам"-ын хэрэгжилтийн хүрээнд сахилга, ёс зүйн зөрчил давтагдаагүй.
НИЙТ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН 100%				
4. АВЛИГА, ХҮНД СУРТЛЫГ ТАСЛАН ЗОГСООХ, АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД				
17.	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Нутгийн захиргааны байгууллагууд иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний сэтгэл ханамжийн судалгаа авна.	Хан-Уул дүүргийн Иргэдэд үйлчлэх төв байрны Нэг цэгийн үйлчилгээний төв болон хороодоор үйлчлүүлсэн иргэнээс төрийн албан хаагчийн үйлчилгээ үзүүлж буй байдлыг дүгнэх сэтгэл ханамжийн судалгааг 2024 оны 12 дугаар сарын 02-06-ны өдрүүдэд авч, судалгааны үр дүнг нэгтгэн 2025 онд хэрэгжүүлэх авлигын эсрэг төлөвлөгөө, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны	Иргэдэд үйлчлэх төв байран дахь төрийн байгууллагуудын төрийн албан хаагчдын албан үүргээ гүйцэтгэхэд үүсгэж буй хүнд суртал, ёс зүйн асуудлыг илрүүлэх, төрийн үйлчилгээний чанарыг

			төлөвлөгөөнд тусгахаар боловсруулсан. Хэрэгжилт 50%	нэмэгдүүлэх суурь нөхцөл бүрдэнэ.
18.		Иргэдээс нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд холбогдох авлига, хүнд суртал, төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой гаргасан гомдол, мэдээллийг бүртгэж холбогдох арга хэмжээ авна.	Иргэдээс Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах төвийн 11-11 утсаар хандсан 9, Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудал хариуцсан мэргэжилтэнд утсаар хандсан 1, албан хаагчаас ирүүлсэн 1, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлсэн 1 гомдол, мэдээллийг бүртгэж, холбогдох хууль, журмын дагуу дүгнэлт гарган шийдвэр гарган ёс зүйн зөрчил тогтоогдсон 3 албан хаагчид эрх, бүхий албан тушаалтны шийдвэрээр ёс зүйн хариуцлага ноогдуулан, 1 албан хаагчид холбогдох мэдээллийн дагуу холбогдох байгууллагад хариу хүргүүлсэн. Хэрэгжилт 100%	Төрийн албан хаагчийн ёс зүй, хүнд суртал, ашиг сонирхлын зөрчил давтагдаагүй.
19.		Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр видео шторк, зурагт хуудас зэргийг байгууллагын цахим хуудаст байршуулж, мэдээлнэ.	Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн албан хаагчдын оролцоотойгоор Хан-Уул дүүрэгт худалдаа, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн, нэгж байгууллага болон иргэдэд худалдаа, үйлчилгээний тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой мэдээллийг үйл ажиллагаа эрхлэгчдэд хүргэх агуулга бүхий видео шторкийн зураг аватыг хийж, дүр эвлүүлэх шатанд явж байна. Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн 4 төрлийн тв шторк, видео график, теле зохиомжийг дүүргийн www.khanuul.mn цахим хуудасны авлигын эсрэг үйл ажиллагааны ил тод буланд байршуулж иргэд, олон нийтэд хүргэсэн. Хэрэгжилт 100%	Иргэд, албан хаагчид авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээллээр хангагдсан.
20.	Албан хаагчдыг соён гэгээрүүлэх	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, авлигыг үл тэвчих ёс зүйг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, арга хэмжээ зохион байгуулна.	- Засаг даргын Тамгын газар болон хорооны төрийн албан хаагчдын өдөр тутмын ажлын хэрэгцээнд зориулж, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн холбогдох заалт бүхий 400 ширхэг дэвтэр хэвлүүлж, нийт албан хаагчидад олгон өдөр тутмын хэрэгцээнд ашиглаж байна.	Төрийн албан хаагчид, хорооны хэсгийн ахлагчид холбогдох хуулийн

			- Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг төрийн албан хаагчдад таниулах, аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд Morning QUIZ арга хэмжээг зохион байгуулж ЗДТГ-ын 70 албан хаагчийг хамруулсан. QUIZ асуултанд дээрх хуулиуд болон хөгжөөнт, танин мэдэхүйн асуултуудаас бүрдсэн бөгөөд эхний 3 байр тус бүр 1 албан хаагч шалгаруулж, мөнгөн шагнал олгосон. - Авлигатай тэмцэх газрын Соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх нь” сэдэвт сургалтыг 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулж, сургалтад 70 албан хаагчийг хамруулсан. Хэрэгжилт 100%	
НИЙТ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН 87.5%				
НИЙТ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН 95%				